



17 Page



18 Page



19 Page



20 Page

Каин ба Абел

-Cain and Abel-

Тайлбарлагч Бурханы анхны бүтээл болох Адам, Ева хоёр хүүхдүүдтэй болов. Ахыг нь Каин, дүүг нь Абел гэдэг байв. Хоёр хүү нь өсөж том болжээ.

Каин нь тариачин байв. Хөлсөө урсган байж ажилласан Каин маш их тариа будаа, үр жимс хураажээ. Дүү Абел нь хоньчин болов. Хоньдоо шимтэй ногоон талаар бэлчээрлүүлж, араатан амьтдаас хамгаалж байлаа.

Тайлбарлагч Нэгэн өдөр, дүү Абел нь хонин сүргийнхээ хамгийн анхны төл ба өөх тосоор Бурханд тахил өргөв. Ах Каин нь ургацаасаа Бурханд өргөв. Гэтэл Бурхан Абелын тахилыг хүлээн авч Каины тахилыг хүлээж авсангүй. Каин маш их уурлан, дүү Абелаа үзэн яджээ.

Каин “Бурхан яагаад Абелын тахилыг л хүлээн авна вэ? Тэр байгаагүй бол Бурхан намайг л хайрлах байсан...”

Тайлбарлагч Бурханд гомдсон гомдол, дүүдээ атаархсан атаархал бүх зүрх сэтгэлийг нь эзэмдсэн байлаа. Нэг өдөр, юу тохиолдох нь энэ вэ? Абел ерөөсөө харагдахгүй байв. Бурхан Каинд хандаж

Бурхан “Каин аа, Абел хаана байна вэ?

Каин “Бурхан минь! Абел хаана байгааг би яаж мэдэх вэ? Би дүүгийнхээ харгалзагч юмуу? Би тариа тариад завгүй, зэрлэг өвсийг нь зулгаах хэрэгтэй шүү.”

Бурхан “Каинаа! Чи дүүдээ юу хийчих нь энэ вэ?

Тайлбарлагч Бурхан болсон бүх явдлыг мэдэж байлаа. Каин Бурханыг хуурч, юу ч мэдээгүй дүр эсгэн, худлаа ярьсан боловч үнэндээ Каин дүүгээ хаана байгааг мэдэж байсан.

Каин Тиймээ.. Абел чи л байхгүй бол!!..ингээд !

Тайлбарлагч Каин Абелыг чулуугаар цохив. Абел их цус алдан үхжээ. Бурхан бүх зүйлийг мэдээд, Каинаас асуусан боловч Каин Бурханыг хуурах гэж оролдов.



21 Page

Бурхан

“Чиний хөнөөсөн дүүгийн чинь цус газраас Над уруу хашхирч байна”, “чи одооноос эхлэн газар хагалахад газар чамд дахин үр жимсээ хайрлахгүй. Чи газар дэлхий дээгүүр хэрэн тэнүүчлэгч болно”

Каин

“Бурхан минь би Таны хараанаас далд орж, газраар хэрэн тэнүүчлэгч болно. Надтай уулзсан хэн боловч намайг ална”

Тайлбарлагч

Бурхан надаас холдчихлоо гэж бодсон Каин хэрэн тэнэсээр үхэх нь гэсэн айдаст автсан байлаа. Хэдий Каин гэмт хэрэгтэн боловч Бурхан түүнийг өрөвдөн хэн ч Каиныг алахгүй гэж амлажээ. Каин, гунигтайгаар уйлан Бурханаас холдон явав. Түүнээс хойш Каин нь Едений зүүн талд нутаглан амьдарчээ.